# АГУУЛГА

БҮЛЭГ 1. ТУХАЙН ОРДЫН УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ........ 3

БҮЛЭГ 2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........ 6

БҮЛЭГ 3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........ 10

БҮЛЭГ 4. БИОЛОГИЙН БОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........ 12

БҮЛЭГ 5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........ 15

БҮЛЭГ 6. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........ 15

БҮЛЭГ 7. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........ 16

БҮЛЭГ 8. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........ 21

БҮЛЭГ 9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ ........ 23

- 9.1. Хөрсний шинжилгээ ........ 23
- 9.2. Усны шинжилгээ ........ 24
- 9.3. Агаарын шинжилгээний дүн ........ 25

БҮЛЭГ 10. АЙМАГ, СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ШААРДЛАГААР БИЕЛҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ ........ 26

БҮЛЭГ 11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ. 28

БҮЛЭГ 12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........ 30

ДҮГНЭЛТ ........ 31

ХАВСРАЛТ: ........ 32

**Зургийн жагсаалт**

Зураг 1. Уурхайн ерөнхий төлөвлөлтийн зураг ........ 3
Зураг 2. Замын тэмдэг тэмдэглэгээ байршуулсан байдал ........ 8
Зураг 3. Зэрлэг амьтан услах уст цэг байгуулсан ........ 8
Зураг 4. Иргэдэд зориулсан тараах материал тараасан байдал ........ 9
Зураг 5. Сумын төвд тариалсан мод ........ 10
Зураг 6. Камер трап байршуулсан байдал ........ 12
Зураг 7. Камерт буусан гэрийн мал ундаалж буй байдал ........ 13
Зураг 8. Ажилчдыг хувцас хэрэглэлээр хангасан байдал ........ 19
Зураг 9. Галын аюулгүй ажиллагааны самбар, галын сараа ........ 20
Зураг 10. Дээж авсан цэгийн байршил ........ 23
Зураг 11. Уурхайн талбайн агаарын чанарын хэмжилт ........ 25
Зураг 12. Аймаг, сумын засаг даргын шаардлагаар биелүүлсэн арга хэмжээ ........ 27

**Хүснэгтийн жагсаалт**

Хүснэгт 1. Техник-эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд ........ 4
Хүснэгт 2. Уурхайн ажлын үргэлжлэх хугацаа ........ 5
Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ........ 6
Хүснэгт 31. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө ........ 12
Хүснэгт 32. Тэрбум модны зардал ........ 14
Хүснэгт 7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт ........ 16
Хүснэгт 8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт ........ 21
Хүснэгт 9. Хөрсний хүнд металлын шинжилгээний үр дүн ........ 23
Хүснэгт 10. Хөрсний ерөнхий химийн шинжилгээ ........ 24
Хүснэгт 11. Усны шинжилгээний үр дүн ........ 24
Хүснэгт 12. Агаарын шинжилгээний үр дүн ........ 25
Хүснэгт 13. Аймаг, сумын засаг даргаар шаардлагаар биелүүлсэн арга хэмжээ ........ 26
Хүснэгт 14. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт ........ 28
Хүснэгт 15. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөх оршин суугчид олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөөний биелэлт ........ 30
Хүснэгт 16. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн зардлын нэгтгэл ........ 31

## БҮЛЭГ 1. ТУХАЙН ОРДЫН УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Бишрэлт түшлэг” ХХК нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугээр сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар шинэчлэн баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу Түшлэг уулын барилгын чулууны ордыг ашиглах төслийн 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг боловсруулаа.

“Бишрэлт түшлэг” ХХК-ийн бутлан ангилах төхөөрөмжийн хүчин чадал нь цагт 40-45 м3 барилгын чулуу бутлан ангилах хүчин чадалтай бөгөөд цагт хамгийн багадаа 40 м3-ийн хүчин чадлаар ашиглах боломжтой байна. Бутлан ангилсан барилгын чулууны хэрэгцээний хувьд орд нь Сайншанд сумаас 17 км зайтай, хатуу хучилттай авто замаар холбогдсон нь гол давуу тал болж байгаа бөгөөд Сайншанд суманд хэрэгжих томоохон төслүүдэд барилгын чулууны үндсэн нийлүүлэгч болох бүрэн боломжтой байгаа тул 2024 ашиглалтын хүчин чадлыг ТЭЗҮ-д тусгагдсаны дагуу уулын ажлын төлөвлөгөөнд жилд 60.0 мян.м3 барилгын чулуу олборлон борлуулахаар төлөвлөсөн бөгөөд энэ жил 27.5 мян.м3 барилгын чулуу олборлосон байна.

**Зураг 1. Уурхайн ерөнхий төлөвлөлтийн зураг**



Хүснэгт 1. Техник-эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд

| № | Үзүүлэлтүүд | Нэгж | Тоо, хэмжээ |
|---|---|---|---|
| 1 | Ордын геологийн нийт нөөц /B+C/ | мян.м$^3$ | 1133.9 |
| 2 | Үйлдвэрлэлийн нөөц | мян.м$^3$ | 847.346 |
| 3 | Хаягдал | мян.м$^3$ | 12.9 |
| 4 | | % | 1.5 |
| 5 | Бохирдол | мян.м$^3$ | 0.9 |
| 6 | | % | 0.8 |
| 7 | Уурхайн жилийн хүчин чадал | мян.м$^3$ | 60.0 |
| 8 | Ажиллах горим: - жилд ажиллах хоног<br>- хоногт ажиллах ээлж<br>- ээлж үргэлжлэх хугацаа | хоног<br>ээлж<br>цаг | 152<br>1<br>12 |
| 9 | Ашиглалтын систем | Авто тээвэр, гадаад овоолготой | |
| 10 | Ажиллагсдын нийт тоо | хүн | 24 |
| 11 | Ордыг ашиглах хугацаа | жил | 15 |
| 12 | Уурхай байгуулах бэлтгэл үе шат | жил | 0.3 |
| 13 | Төслийн хүчин чадлаар ажиллах хугацаа | жил | 14 |
| 14 | Бутлан ангилах үйлдвэрийн байршил | Тусгай зөвшөөрөл бүхий талбайдаа | |
| 15 | Бүтээгдэхүүний жилийн гарц 0-5мм<br>5-10мм<br>10-20мм<br>20-40мм | м$^3$ | 9000<br>6000<br>36000<br>9000 |
| 16 | Бүтээгдэхүүн борлуулалтын орлого | сая.төг | 17775.0 |
| 17 | Хөрөнгө оруулалтын хэмжээ | сая.төг | 1286.0 |
| 18 | Хөрөнгө оруулалт нөхөн төлөх хугацаа | жил | 5 |
| 19 | Төслийн ашгийн дотоод норм, IRR | % | 33 |
| 20 | Төслийн ирээдүйн мөнгөний үнэ цэнэ NPV, сая төгрөг | 10% | 1,837.33 |
| 21 | 1м$^3$ барилгын чулууны бүрэн өөрийн өртөг | мян.төг | 14.6 |
| 22 | Улсад төлөх нийт татвар төлбөрийн хэмжээ | сая.төг | 2233.01 |
| 23 | Цэвэр ашиг | сая.төг | 4175.1 |
| 24 | Уулын үндсэн тоног төхөөрөмжүүд: | | |
| 25 | Экскаватор | 1 | |
| 26 | Дугуйт ачигч | 2 | |
| 27 | Автосамосвал, 25тн | 3 | |
| 28 | Өрмийн машин | 1 | |
| 29 | **Бульдозер** | 1 | |

**Уурхайн дотоод тээвэр, овоолго**

Уурхайгаас жилд 60.0 мян.м3 барилгын чулуу олборлож, 3.8 мян.м3 шимт хөрс хуулж тээвэрлэж овоолгуудад байршуулахаар байна. Уурхайн тээвэр гүйцэтгэх шаардлагатай ажлуудын төрөл, хэмжээ:

Шимт хөрсний тээвэр: Ил уурхай → шимт хөрсний овоолго. Энэ нь хөрс хуулалтын ажлын үндсэн хэсэгт багтах бөгөөд дунджаар 0.8 км зайд тээвэрлэнэ. Нийт замын 80% нь ачаатай чиглэлд.

Хүдрийн тээвэр: Ил уурхай → дайрга хүлээн авах талбай. Ил уурхайн олборлолтын мөргөцгөөс ачих техникээр ачиж дайрга хүлээн авах талбай хүртэл тээвэрлэнэ. Тээврийн дундаж зай 0.9-1.0 км.

Овоолго байгуулах талбайн гадаргуу нь толгодорхог, ерөнхийдөө налуу нь 2-3° байгаа нь чулуулгийн нуралтын хязгаараас доогуур үзүүлэлт юм. Доголын налууг үндсэн чулуулгийн дотоод үрэлтийн өнцөгтэй ижил утгаар авснаар гулсалт болон нуралт үүсэх магадлал бага юм. Доголын өндөр 15 м, налуугийн өнцөг 34° байна.

**Бутлан ангилах технологи**

Түшлэг уулын барилгын чулууны ил уурхайгаас жилд 60.0 мян.м3 чулуу олборлон үйлдвэрийн хэсэгт бутлан, ангилж 0-5 мм, 5-10 мм, 10-20 мм, 20-40 мм-ийн дайрга үйлдвэрлэн хэрэглэгчид нийлүүлнэ.

**Бутлан ангилах цехийн ажиллах горим**

Бутлан ангилах үйлдвэрийн ажлын горимыг захиалагчаас өгсөн техникийн даалгаврын дагуу уурхайн ажиллах горимтой ижил 5-р сарын 01-ээс 10-р сарын 31 хүртэл ажиллахаар тооцлоо. Долоо хоногт амралтын нэг өдөртэй, 12 цагийн үргэлжлэлтэй 1 ээлжээр ажиллуулахаар төлөвлөв.

Хүснэгт 2. Уурхайн ажлын үргэлжлэх хугацаа

| № | Ажиллах горимын үзүүлэлтүүд | Хэмжих нэгж | Тоогоор |
|---|---|---|---|
| 1 | Жилийн хуанлийн хоног | хоног | 365 |
| 2 | Улирлын чанартай сул зогсолт /11.01-04.30/ | хоног | 181 |
| 3 | Улс нийтээр амрах, баяр ¸ёслолын өдрүүд /05.01-10.30/ | хоног | 7 |
| 4 | Цаг агаарын хүндрэлээс шалтгаалсан сул зогсолт | хоног | 10 |
| 5 | Засвар үйлчилгээнд зарцуулах сул зогсолт | хоног | 15 |
| 6 | Жилийн бодит ажиллах хоног | хоног | 152 |
| 7 | Уулын ажил явагдах хоног | хоног | 152 |
| | Хоногт ажиллах ээлж | ээлж | 1 |
| | Ээлжийн үргэлжлэх хугацаа | цаг | 12 |
| 8 | Бутлах цех ажиллах хоног | хоног | 152 |
| | Хоногт ажиллах ээлж | ээлж | 1 |
| | Ээлжийн үргэлжлэх хугацаа | цаг | 12 |

40 м3/цаг хүчин чадалтай дайрганы үйлдвэр. Энэ үйлдвэр нь цагт 107 тн /40 м3/ дайрга боловсруулж 0-5 мм, 5-10 мм, 10-20 мм, 20-40 мм-ийн дайрга үйлдвэрлэн хэрэглэгчид нийлүүлнэ.

## БҮЛЭГ 2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Болзошгүй гол сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн юм. Болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг нөлөөлөлд өртөж болзошгүй бүрэлдэхүүн тус бүрээр нь ангилан тодорхойлж арга хэмжээг хэрэгжүүлсэн. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу төв замар уурхайн талбай хүртэлх талбайд 10 ш анхааруулах тэмдэг тэмдэглэгээ байршуулсан. Мөн Хөрс, ус, агаарын мониторингийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн ан амьтныг хамгаалах талаар ундаалах уст цэгээс гадна хууль бус ан агнууртай тэмцэх ухуулга сургалчилгаа, зураг хуудсийг 50 ш хэвлэж тараасан. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардалд нийт 3410.0мян.төг зарцуулсан.

Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

| Байгаль орчныг хамгаалахад хэрэгжүүлсэн арга хэмжээ | Хамарсан цар хүрээ | Хэмжих нэгж | Хэмжээ | Нэгжийн үнэлгээ /төг/ | Нийт зардал /мян.төг/ | Тайлбар | Хэрэгжүүлсэн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Замын-үүд чиглэлийн авто замаас талбайгаас уурхай хүртэлх замд замын тэмдэг тэмдэглэгээ байршуулах** | Төв замаас уурхай хүртэл | 1 км | 10 | 30 000 | 300 000 |  | 100% |
| **Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг тогтоох, бууруулахын тулд хяналт шинжилгээг тогтмол хэрэгжүүлнэ.** | Уурхайн талбай | ш | 6 удаа | 12000 | 72 000 | Дорноговь аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн байгаль орчны шинжилгээний | 100% |

| Байгаль орчныг хамгаалахад хэрэгжүүлсэн арга хэмжээ | Хамарсан цар хүрээ | Хэмжих нэгж | Хэмжээ | Нэгжийн үнэлгээ /төг/ | Нийт зардал /мян.төг/ | Тайлбар | Хэрэгжүүлсэн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | лабораторид шинжлүүлсэн. | |
| **Уурхайн хогийн цэг, бие засах газруудад ариутгал халдваргүйжүүлэлт хийх** | Хогийн цэг, бие засах газар | Ш | 12000 | 6 | 72 000 |  | 100% |
| **Зэрлэг ан амьтанд зориулан ундаалах цэг байгуулна** | Уурхайн лицензийн талбай дотор | ш | 1 | | 2000 000 | Зэрлэг ан амьтан услах уст цэг байгуулсан бөгөөд энд сард 1 удаа 1 тн ус хийдэг байна. мөн ан амьтан ангахыг сэргийлж тараах 50ш материалыг тараасан байна. | 100 |
| **Нийт** | | | | | **2444 000** | | |

**Зураг 2. Замын тэмдэг тэмдэглэгээ байршуулсан байдал**



| | |
|---|---|
| Тайлбар: | Замын тусгай анхааруулсан тэмдэг, тэмдэглэгээ байршуулсан байдал |
| Огноо: | 2023.10.08 |

**Зураг 3. Зэрлэг амьтан услах уст цэг байгуулсан**



Зураг 4. Иргэдэд зориулсан тараах материал тараасан байдал



"БИШРЭЛТТҮШЛЭГ" ХХК

БАРИЛГЫН БОЛОН ЗАМЫН ХАЙРГА БУТЛАН АНГИЛАХ ҮЙЛДВЭР

"Бишрэлт түшлэг" ХХК нь 2012 онд байгуулагдсан Барилгын болон замын дайрга бутлан ангилах үйл ажиллагаа эрхлэн явуулдаг. Дорноговь аймгийн Өргөн сумын Түшлэг уул хэмээх газарт 84.5 га газарт түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшин уулын чулуу олзворлон бутлан ангилаж аймгийн хэмжээний барилгын болон автозамын гүйцэтгэгч байгууллагуудад бэлтгэн нийлүүлж байна. Тус үйлдвэр нь Сайншанд сумаас зүүн урагш Замын үүд чиглэлийн авто замын дагуу 22 км зайд оршдог.

Манай үйлдвэр нь Сайншанд суманд хийгдэж буй Газрын тос боловсруулах үйлдвэрийн дэд бүтэц төслийн авто зам төмөр замын бүтээн байгуулалт, Сайншанд салхин парк төсөл, Таван толгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам төсөл, Газрын тос боловсруулах үйлдэрийн "орон сууц "төсөл зэрэг томоохон бүтээн байгуулалтын ажилд хамтран ажиллаж 5-10 мм, 10-20 мм, 20-65мм ширхэглэл бүхий дайрга бэлтгэн нийлүүлж байна

Манай компани нь барилгын материалын үйлдвэрлэл: 3.3.1 -дүүргэгч материал элс хайрга чулуу бутлан ангилах үйлдвэрлэл гэсэн БМҮ 093/17 дугаар бүхий Барилга хот байгуулалтын яамнаас олгосон тусгай зөвшөөрөл эзэмшдэг.

Уулын чулуут тусгай зөвшөөрөл бүхий өрөмдлөг тэсэлгээний компанитай гэрээ хийж тэсэлгээний ажлыг гүйцэтгүүлдэг Тэсэлсэн чулуут экскаватороор олзворлон авто машинд ачиж үйлдвэрийн хүлээн авах бункерт хийж үйлдвэрийн үйл ажиллагаа явагддаг Үйлдвэрлэгдсэн дайргыг авто ачигчаар машинд ачиж тусгай талбайд ширхэглэл тус бүрээр хурааж хадгална

Үйлдвэрлэсэн дайрганаас байнга дээж авч өөрийн компаний лабораторт шинжлэн хяналт тавьдаг

Мөн дайрганаас дээж авч аймгийн ГХБХБГазрын болон Улаанбаатар хотын БАК- ын лабораторт өгч шинжилгээ хийлгэж баталгаажуулдаг



АМЬТНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАЖ, ХУУЛЬ БУСААР АН АМЬТАН АГНАХ ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЬЕ

Төрийн захиргааны төв байгууллагаас тухайн жилд амьтан агнах, барихаар тогтоосон дээд хэмжээнд багтаан иргэн, аж ахуйн нэгжүүд зөвшөөрөл авахгүйгээр амьтан агнаж, барих, амьтдын амьдралын онцлогийг харгалзан хуулиар агнах, ашиглахыг хориглосон хугацаанд хууль бусаар ан амьтан агнах, барих зөрчил гаргаж эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээх, ан агнуурын нөөцөд сөрөг нөлөө үзүүлэхээс урьдчилан сэргийлж Амьтны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхийг Хэнтий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас зөвлөж байна. Агнуурын амьтан агнах, агнах болон барихыг хориглох хугацаа Монгол Улсын Амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлд цагаан зээрийг 12 дугаар сарын 1-ний өдрөөс дараа оны 8 дугаар сарын 31-ний өдөр хүртэл агнах, барихыг хориглоно.

Цагаан зээр –Pricarpagutturosa

Зөрчилд хүлээлгэх хариуцлага: Хуульд заасны дагуу зөвшөөрөл авалгүйгээр бор гөрөөс агнасан иргэн, хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүйгээр бол байгаль орчны хяналтын улсын байцаагч дор дурдсан захиргааны хариуцлага ногдуулна.

Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйл Хугацаа дууссан гэрээ, зөвшөөрлөөр, эсхүл гэрээ, зөвшөөрөлгүйгээр амьтныг ашигласан, барьсан, агнасан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хураах, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж иргэнийг 150 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг 1500 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Амьтны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалтаар: Төлбөр төлж тусгай зөвшөөрөл авалгүйгээр бор гөрөөс агнасан, барьсан гэм буруутай этгээдэд нөхөн төлбөрийн хэмжээг Засгийн газрын 2011 оны 23 тоот тогтоолоор баталсан "Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ"-гээр: Ооныг-500.000 төгрөгөөр

Шаргачинг–550.000 төгрөгөөр тус тус үнэлж байгаль орчны хяналтын улсын байцаагчийн актаар уг үнэлгээг хоёр дахин өсгөн нөхөн төлүүлнэ.

Зөвшөөрөл:

БОАЖ-ын сайдын тушаалаар тогтоосон тухайн жилийн хяналтын тоонд багтаах Амьтны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5 -д заасны дагуу Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 26.2-т заасан агнуурын амьтны тоо хэмжээнд багтаан харьяалах нутаг дэвсгэрт агнуурын амьтан агнах, барих зөвшөөрлийг иргэн, хуулийн этгээдэд олгох болно. 29.1-т заасны дагуу тусгай төлбөр төлсөн иргэнд энэ хуулийн 24.3.3-т заасан зориулалтаар агнуурын амьтан агнах, барих тусгай зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллага олгоно.

Төлбөр хураамж:

Иргэн , хуулийн этгээд Амьтны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 болон Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 мөн 17.1.5-д заасны дагуу Засгийн газрын 2011 оны 23 тоот тогтоолоор батлагдсан "Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хувь хэмжээ"-г баримталсан нэг толгой цагаан зээрийн оныг-100.000, шаргачинг-110000 төгрөгийг үйлдвэрлэлийн бус зориулалтаар агнахад тус бүрд нь орон нутгийн төсвийн орлогын дансанд урьдчилан тушаах ба харин гадаадын иргэнд тусгай төлбөртэйгээр агнуулахдаа нэг толгой олзворын жишиг үнэ 250, төлбөр 200, хураамж 50 тус тус ам долларыг нэмж урьдчилан тушаана.

БАЙГАЛЬ, ЗЭРЛЭГ АН АМЬТДАА ХАЙРЛАН ХАМГААЛЦГААЯ

НЭН ХОВОР АМЬТАН - АРГАЛЬ

Ховор зүйл. ДБХХ-ны Улаан дансны ангилалын шалгуураар олон улсын хэмжээнд "эмзэг", бүс нутгийн хэмжээнд "устаж болзошгүй" зэрэглэлээр үнэлэгдсэн.

Таних шинж: Биеийн урт 150см (сүүлний үзүүрээс толгойн дагз хүртэлх хэмжээс), сэрвээний өндөр 125см, жин 180кг хүрнэ. Угалз, хонь (эм аргаль) хоёулаа эвэртэй. Угалз 125см урт, 25кг том эвэртэй. Хонины эвэр угалзныхаас жижиг нарийхан, урт 20-30см. Их бие зүс хүрэн бор, хүрэвтэр. Хэвлэл цайвар.

Тархац, байршил нутаг: Монгол Алтай, Говь-Алтай, тэдгээрийн салбар уулс, Зүүнгарын болон Алтайн өвөр говийн уулс, Өмнөговь, Дорноговийн бэсрэг уулс, Төв халхын тал хээрийн зарим намхан уулс, Хан хэнтийн нуруу, Хангайн хөвчийн нуруу, түүний өмнө бэлийн уулсаар хэсэгчилсэн тархацтай. Өндөр нам уулс, арваг толгод, довцог, манхан элс зэрэг бартаа сархиа, нугачаа бүхий ой модгүй газар идээшилнэ. Алтайн нуруунд 3500 м хүртэл, Өмнөговь, Алтайн өвөр говьд 1100 м-ээс дээш, Хөвсгөлд 1250-2500м өндөрт нутаглана. Хээр цөлийн бэсрэг уулс, арваг толгодод цас, задгай ус, өвс ногоо дагаж улирлаар хол ойр нүүдэллэж бэлчээрээ сэлгэдэг.

Амьдралын онцлог: Сүрэглэн амьдарна. Намар, өвөлд олноороо сүрэглэнэ. Зун өглөө болон оройн сэрүүнд, харин өвөл өдөржин идээшилнэ. Элдэв зүйлийн өвслөг ургамлууд, үет ургамал голдуу идно. Өвөлд сөөглөг ургамлын мөчир идно. Ус болон бэлчээрийн нөөцөөс хамаарч улирлаар бэлчээрээ сэлгэж байршина. Ороо нийлэгт X-XI сард орж, IV-V сард хургална. Угалз 20 хүртэл хонь хураана. Үржилд 3-4 настайгаасаа орно. Байгалийн нөхцөлд 10-18 жил насалдаг. Тоо толгой, хомсдох шалтгаан: Байгаль, цаг уурын онцлогоос шалтгаалан тоо толгой ихээхэн хэлбэлзэнэ. Монгол Алтай, Говь Алтайн зарим нутагт элбэг, Хангайн хөвчийн нуруу, зах бэлийн уулсад ховор, Өмнөговийн уулсаар ховордуу, Дундговь, Дорноговийн намхан уулсаар ховор тохиолдоно. Монголд далаад оны сүүлчээр, 40 орчим мянган толгой аргаль байснаас, Хөвсгөлд 200 орчим тохиолдоно. 2001 онд 13000-15000 толгой, 2009 онд хийсэн уулын туруутны судалгаагаар, аргаль хонь Монгол улсын хэмжээнд 50215.4 км2 талбайд тархсан бөгөөд дунджаар 18100 толгой нөөцтэй гэж үнэлжээ. Мөн сүүлийн 10 орчим жилд Хөвсгөл, Сүхбаатар аймагт аргаль хонины тоо толгой харьцангуй тогтмол, харин тархац нутгийн хэмжээ 9.7-8.9 дахин нэмэгдсэнээс Говьсүмбэр аймагт тархац нутгийн хэмжээ 3.2 дахин, Төв аймагт 2.3 дахин, Баянхонгор, Дорноговь, Баян-Өлгий, Увс аймгуудад 1.2-1.9 дахин нэмэгдсэн, Хэнтий, Ховд, Өмнөговь, Өвөрхангай, Дундговь аймагт аргаль хонины тархац нутгийн хэмжээ 1.1-2.3 дахин багассан болохыг тогтоожээ.

## БҮЛЭГ 3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2025 оны хувьд уурхайн ашиглалтын карьерт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийхгүй.

Өргөн сумын төвийн бүх нийтийн талбайд 1000 мод тарьж, усалгааны системийн хамт хүлээлгэж өгсөн байна. Энэхүү ажлын зардалд 2510 000 төгрөгөөр 1000 ширхэг мод худалдаж авсан. Сумын засаг даргын тодорхойлолтыг хавсралтаар үзүүлэв.

**Зураг 5. Сумын төвд тариалсан мод**








ӨРГӨН СУМЫН ЦЭЦЭРЛЭГ 1000 МОДНЫ
УСАЛГААНЫ СИСТЕМ


ӨРГӨН СУМЫН ХАВЦГАЙ ГАЗРЫН НӨХӨН
СЭРГЭЭЛТ

## БҮЛЭГ 4. БИОЛОГИЙН БОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Монгол улсын Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Уул уурхайн хүнд үйлдвэрийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд нарийн хамтарсан 167, А/698, А/336, А242 тушаалын дагуу нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах тухай Засгийн газрын 2020 -2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, олон жил орхигдсон 8000 га талбайг нөхөн сэргээх зорилтыг хангах, нөхөн сэргээлтийн ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газраас Хавцгай нэртэй талбайг санал болгосон.

Бишрэлт түшлэг ХХК-ийн дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөндөө сум, орон нутгийн санаачилсан ажилд идэвхтэй оролцох арга хэмжээг авахаар төлөвлөсөн.

**Хүснэгт 4. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө**

| № | Дүйцүүлэн хамгаалах зорилт | Хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Тоо хэмжээ | Нийт зардал, төг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Түшлэг ууланд биологийн олон янз байдлын судалгаа хийх | Амьтны судалгаа | Түшлэг уул | Тооцох боломжгүй | 2500 000 | 8-9 сард |
| | **Нийт** | | | | 2500 000 | |

Зэрлэг ан амьтанд зориулан ундаалах цэг байгуулсан. Энэхүү ажлаа үр дүнтэй байгаа эсэхийг ажиглахын тулд уст цэгийн орчимд камер трап буюу амьтны хөдөлгөөнөөр мэдэрч зураг, бичлэг хийдэг камерыг байршуулан ажиглалт хийсэн. Ингэхэд уст цэгт зэрлэг ан амьтан ажиглагдаагүй ч гэрийн мал ихээр ирж ундаалсан байна.

**Зураг 6. Камер трап байршуулсан байдал**



Аймгийн нийт нутгийн 40 хувь нь зуншлага сайн, 36 хувь нь зуншлага хэвийн, 24 хувь нь гандуу байна. Аймгийн хувьд өвөл-хаврын бэлчээрийн даац нутгийн 80.1 орчим хувьд хүрэлцээтэй, 19.9 орчим хувьд хэтэрч гарсан байна.

Энэ жил зуншлага сайтай, өвс ногоо элбэг байсан тул зэрлэг ан амьтдын идэш тэжээл хангалттай байсан бөгөөд тэд камерт өртөөгүй байна.

**Зураг 7. Камерт буусан гэрийн мал ундаалж буй байдал**









Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн санаачилсантай холбоотойгоор Өргөн суманд 100 мод тарихаар төлөвлөлөө. Энэхүү ажлын зардалд 750 000 төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.

**Хүснэгт 5. Тэрбум модны зардал**

| **Материалын нэр** | | **Хэмжих нэгж** | **Тоо хэмжээ** | **Нэгж үнэ, төг** | **Нийт үнэ, мян.төг** |
|---|---|---|---|---|---|
| **1** | Хайлаас | ш | 50 | 10000 | 500000 |
| | Улиас | ш | 50 | 5000 | 250000 |
| **Нийт** | | | | | 750 000 |

## БҮЛЭГ 5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Тухайн төслийн үйлдвэрлэлийн болон эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллага байхгүй байна. Иймд нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө тусгагдаагүй болно.

## БҮЛЭГ 6. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Соёлын өвийг хамгаалах тухай” Монгол улсын хуулийн 2014 оны 5 сарын 15 ны өдрийн шинэчлэсэн найруулгын 5.1.1; 6.1.5; 16.7.1; 17.1.3,4; 27.2; 28-р зүйл, 38.2,3; 60.1.10-д заасны дагуу газрын хэвлийг эзэмших ашиглахад палеонтологийн хайгуул тандан судалгааны ажлыг хийлгэх шаардлагатай байдаг. Уг хуулийн зорилго нь соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж хамгаалах, сурталчлах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулах, өмчлөх, эзэмших, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
Төслийн талбайгаас олдвор олдоогүй

## БҮЛЭГ 7. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Уурхайн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах гол арга зам бол осол, эрсдэлийг гаргахгүй байх юм. Иймээс уурхай нь 2025 онд аюулын үед авч хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж батлуулахаар төлөвлөсөн. Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэл, өглөө бүр ХААБ сургалтыг хийхээр төлөвлөсөн. Мөн авто ослоос сэргийлэн анхааруулах тэмдэг тэмдэглэгээ 20 ш сэргээхээр төлөвлөсөн. Эдгээр ажлын зардалд 1650 000 төгрөг зарцуулах бөгөөд ажилчдын хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангах зардлыг үйл ажиллагааны зардалд тусгахаар төлөвлөсөн.

Хүснэгт 6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

| Байгаль орчныг хамгаалахад хэрэгжүүлсэн арга хэмжээ | Хамарсан цар хүрээ | Хэмжих нэгж | Хэмжээ | Нэгжийн үнэлгээ төг/ | Нийт зардал /мян.төг/ | Тайлбар | Хэрэгжүүлсэн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **2025 оны аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах** | Аюулын үед авч хэрэгжүүлэх төлөвлөгөө 2025 батлуулах | Уурхайн бүх объектод хамаарна | 1 | 500 000 | 500 000 |  "БИШРЭЛТ ТҮШЛЭГ" ХХК-ИЙН БАРИЛГЫН БОЛОН ЗАМЫН ДАЙРГА БУТЛАН АНГИЛАХ ҮЙЛДВЭРИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Ажилчид гэмтэж бэртэх** | Ажилчдыг хөдөлмөр хамгаалалтын хэрэгслээр хангаж ажиллах | Бүх ажилчид Өвөл намрын хувцас | Үйл ажиллагааны зардалд орсон. | | |   | 100 |
| **Гал түймэр гарах** | Төслийн талбайд галын хор байршуулах | Кемп, үйлдвэр, засварын цэгт | 4 | 250 000 | 1000 000 |  | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **Ажилчдын хайхрамжгүй үйлдлээс болж осол гарах** | Ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны сургалт явуулах | Бүх ажилчид | Өдөр бүр | ХААБ мэргэжилтэн сургалтыг явуулсан. |  | 100 |
| **Авто ослоос сэргийлэх** | Анхааруулах тэмдэглэгээг сэргээх | Ш | 20 | 200 000 | Засаж сайжруулсан. | 100 |
| **Нийт** | | | | 1700 000 | | 100 |

Зураг 8. Ажилчдыг хувцас хэрэглэлээр хангасан байдал



Зураг 9. Галын аюулгүй ажиллагааны самбар, галын сараа






## БҮЛЭГ 8. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Энэхүү төсөл нь нийт 15 жилийн хугацаанд хэрэгжих тогтвортой төсөл учраас хог хаягдлыг ангилан ялгах, аюултай хог хаягдлыг тусад нь хадгалах зэрэг үйл ажиллагаанууд хэрэгжүүлж ажилласан. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар баталсан хог хаягдлыг ангилан ялгах менежментэд хэвшүүлэх ажилчдад хог хаягдлыг ягаад ялгах тухай сургалтыг хийх, мөн уурхайн кемпэд 1 ширхэг ангилан ялгах зориулалттай хогийн савыг суурилуулах, аюултай хог хаягдлыг ахуйн хаягдлаас тусад нь хадгалах зориулалттай контейнерт хадгалах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

**Хүснэгт 7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт**

| Байгаль орчныг хамгаалахад хэрэгжүүлсэн арга хэмжээ | Хамарсан цар хүрээ | Хэмжих нэгж | Хэмжээ | Нэгжийн үнэлгээ /мян.төг/ | Нийт зардал /мян.төг/ | Тайлбар | Хэрэгжүүлсэн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Ахуйн хог хаягдлыг ангилан ялгах** | Хог хаягдлын гэрээг Өргөн сумын ЗД-тай гэрээ байгуулах төлбөр төлөх | - | - | - | УАЗ-д тусгасан |  | 100 |

БАТЛАВ. ДОРНОГОВЬ АЙМГИЙН ӨРГӨН СУМЫН ЗАСАГ ДАРГА Г.БАЯРБОЛД

ХОГ ХАЯГДЛЫН ГЭРЭЭ

№12

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Хог хаягдлын тухай хуулийн 8.4, 9.2, 20.1,20.2, Сумын ИТХ-ын 2023 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн 10/07 дугаар тогтоолыг үндэслэв.

1.2 Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд учруулах хортой нөлөөллийг арилгах түүнээс урьдчилан сэргийлэх ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, тээвэрлэх, булах болон орчны эрүүл цэвэр тогтмол цэвэр байлгах, цэвэр эрүүл орчинд ажиллах амьдрах орчныг бий болгоход оршино.

Хоёр. Гэрээ байгуулагч талууд

2.1 Нэг талаас Дорноговь аймгийн Өргөн сумын ЗДТГ-ыг төлөөлж Байгаль орчны бодлогын мэргэжилтнийг түр орлон гүйцэтгэгч Э.Баярсүрэн нөгөө талаас 3311007 дугаар регистрийн "Бишрэлт түшлэг" ХХК- ийн захирал Э.Уранчимэг нар харилцан тохиролцож 2024 оны 01 дугаар сарын 02-ны өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-нийг хүртэл хугацаатайгаар энэхүү гэрээг байгуулав.

Гурав. Сумын ЗДТГ-ын эрх үүрэг

3.1 Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль Хог хаягдлын хуулийн дагуу хяналт тавьж ажиллана.

3.2 Аж ахуй нэгж байгууллагын барилгын хог хаягдал гаргасан хураамжийг Сумын ИТХ-ын 2023 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн 10/07 тоот тогтоолоор Ахуйн хэрэглээний хог хаягдал уурхайн 1 сарын 50.000 төгрөгөөр тооцно.

Дөрөв. "Бишрэлт түшлэг" ХХК-ийн хүлээх эрх үүрэг

4.1.Өөрийн байгууллагын үйл ажиллагаанаас гарсан ахуйн хог хаягдал, Үйлдвэрлэлийн хог хаягдлыг стандартын шаардлага хангасан зориулалтын саванд ангилан хадгалж байх.

4.2.Аж ахуйн нэгж байгууллага нь хог хаягдал гаргасны хураамжийг сумын төрийн сан банны 100060700947 тоот дансанд бүрэн төлөх

4.3.Тус сумын нутагт төлөх нийт төлбөр:
12 сар*50,000 /1 сарын төлбөр/=600,000 /зургаан зуун мянган төгрөг/.

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Ахуйн гаралтай хог хаягдлын ангилан ялгаж байх** | Төслийн хүрээнд | | | | 350 000 |  | 100 |
| **Ангилан ялгасан хог хаягдлыг улиралд нэг удаа Эко говь дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх** | Төслийн хүрээнд | - | - | - | | Хог хаягдлын гэрээ байгуулсан. | 100 |
| **Бохир ус соруулдаг байгууллагаар соруулан зайлуулах** | Нүхэн жорлон | - | - | - | 300 000 | Мэргэжлийн байгуулагаар шаардлагатай үед соруулдаг. | 100 |
| **Ашиглагдсан тос, тосолгооны материал, аккумляторыг тусгай цэг гарган төслийн талбайд 150 хоног хадгалан дахин ашиглах цэгт хүргүүлж байх** | Засварын газарт | - | - | - | 400 000 |  | 100 |
| **Ажилчдын ариун цэврийн өрөө, жорлонг Тамир эм бэлдмэлийн ариутгалын бодисоор ариутгах** | Жорлон | ш | 80 | 5000 | 400 000 | Ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн. | 100 |
| Нийт | | | | | **1450 000** | | **100 хувь** |

## БҮЛЭГ 9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Орчны хяналт шинжилгээ хөтөлбөрийн хүрээнд Дорноговь аймгийн ус цаг уур, орчны шинжилгээний төвийн байгаль орчны шинжилгээний лабораторид, хөрсний хүнд метал, эрүүл ахуйн шинжилгээ, усны ерөнхий химийн шинжилгээ, мөн агаарын хүхэрлэг хий, азотын давхар исэл, нийт тоос тоосонцрын шинжилгээг хийлгэсэн.

### 9.1. Хөрсний шинжилгээ

Хөрсний хүнд металлын шинжилгээг 2 цэгээс авсан бөгөөд төслийн талбайд шинжилгээг хийж гүйцэтгэсэн. Хөрсний хүнд металлын шинжилгээний үр дүнд MNS5850-2019 стандартын шаардлагаас давсан үзүүлэлт байхгүй байна.

**Зураг 10. Дээж авсан цэгийн байршил**




**Хүснэгт 8. Хөрсний хүнд металлын шинжилгээний үр дүн**

| Дээж авсан газар, Газар зүйн байршил | Дээж авсан гүн, см | Cr | Pb | Cd | Zn | Cu | Ni |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | мг/кг | мг/кг | мг/кг | мг/кг | мг/кг | мг/кг |
| Зам | 0-10 | 0.0 | 5.0 | 0.0 | 8.5 | 10.9 | 5.6 |
| Кемп | 0-10 | 33.4 | 5.0 | 0.0 | 3.8 | 10.3 | 3.0 |
| Зөвшөөрөгдөх дээд хэмжээ, MNS 5850:2019 | | | | | | | |
| Элсэрхэг хөрс | | 60 | 50 | 1 | 100 | 60 | 60 |
| Шавранцар хөрс | | 100 | 70 | 1.5 | 150 | 80 | 100 |
| Шаварлаг хөрс | | 150 | 100 | 3 | 300 | 100 | 150 |

*Харгалзах түвшин   * Жич: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжинд хамаарна.

**Хүснэгт 9. Хөрсний ерөнхий химийн шинжилгээ**

| № | Цэгийн нэр | pH | Чийг % | Нитратын азот $/NO_3/$ мг/кг | Сульфат $/SO_4/$ мг/кг | Фосфор $/P_2O_5/$ мг/кг | Аммиакийн азот $/NH_4/$ мг/кг | Ялзмаг % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бутлуурын хэсэг N 44°48'06.7" E 110°19'48.1" | 8.97 | 4.14 | 20.90 | 304.5 | 68.26 | 9.12 | 0.19 |
| 2 | Карерь N 44°48'01.1" E 110°19'39.8" | 9.00 | 3.77 | 3.95 | 46.0 | 21.78 | 8.29 | 0.59 |
| 3 | Харьцуулсан хөрс N 44°48'07.3" E 110°19'71.0" | 8.85 | 1.97 | 1.84 | 29.2 | 58.64 | 8.94 | 2.04 |

## 9.2. Усны шинжилгээ

Дорноговь аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн байгаль орчны шинжилгээний лабораторид усан хангамжийн худгаас 9 сарын 30-ны өдөр дээж авч шинжлүүлсэн.

**Хүснэгт 10. Усны шинжилгээний үр дүн**

| № | | Бишрэлт Түшлэг гүний худгийн ус N 44°53'81.3" E 104°08'38.1" | Чандмань илч худгийн ус N 44°53'81.3" E 104°08'38.1" | MNS 0900:2018 |
|---|---|---|---|---|
| 1 | Усан орчин /pH/ | 7.95 | 7.86 | 6.5-8.5 |
| 2 | Цахилгаан дамжуулах чанар /EC/ μS/cm/ | 1187 | 1282 | - |
| 3 | Кальцийн ион /Ca/ мг/л | 31.3 | 34.1 | 100 |
| 4 | Магнийн ион /Mg/ мг/л | 3.4 | 14.8 | 30 |
| 5 | Сульфатын ион $/SO_4/$ мг/л | 361 | 506 | 500 |
| 6 | Хлорын ион /CL/ мг/л | 134 | 115 | 350 |
| 7 | Гидрокарбонатын ион $/HCO_3/$ мг/л | 226 | 229 | - |
| 8 | Эрдэсжилт мг/л | 1084 | 1264 | - |
| 9 | Хатуулаг экв/л | 1.8 | 2.9 | 7.0 |
| 10 | Жинлэгдэх бодис | 18 | 14 | - |
| 11 | Перманганатын исэлдэх чанар мг/л | 0.5 | 0.3 | - |
| 12 | Аммонийн азот $/NH_4/$ мг/л | 0.02 | 0.17 | 1.5 |
| 13 | Нитритийн азот $/NO_2/$ мг/л | 0.001 | 0.002 | 1 |
| 14 | Нитратийн азот $/NO_3/$ мг/л | 0.11 | 2.32 | 50 |
| 15 | Эрдэс фосфор $/PO_4^{3}/$ мг/л | 0.111 | 0.114 | 3.5 |
| 16 | Фтор /F/ мг/л | 1.29 | 0.83 | 0.7-1.5 |
| 17 | Төмөр /Fe/ мг/л | 1.01 | 0.06 | 0.3 |

## 9.3. Агаарын шинжилгээний дүн

Агаарын шинжилгээг 2025 оны 9 сарын 30ны өдөр Дорноговь аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний лабораторийн агаарын чанарын Dustrack 6000 маркийн багажаар 20 минутын хэмжилтийг бутлуурын хэсэг, карерь хэсэгт гүйцэтгэсэн.

Зураг 11. Уурхайн талбайн агаарын чанарын хэмжилт



Агаарын шинжилгээний үр дүнд агаарын чанар техникийн ерөнхий шаардлага MNS4585:2016 стандартаас давсан үзүүлэлт байхгүй байна.

Хүснэгт 11. Агаарын шинжилгээний үр дүн

| № | Дээж авсан цэгийн нэр | Хүхэрлэг хий, $SO_2$ мг/м$^3$ | Азотын давхар исэл, $NO_2$ мг/м$^3$ | Нийт тоосны агууламж мг/м$^3$ |
|---|---|---|---|---|
| 1 | Бутлуурын хэсэг N 44°48'06.7" E 110°19'48.1" | 0.017 | 0.036 | 2.58 |
| 2 | Карерь N 44°48'01.1" E 110°19'39.8" | 0.007 | 0.011 | 0.029 |
| ЗДХ | MNS4585:2025 | 0.450 | 0.200 | 0.500 |

## БҮЛЭГ 10. АЙМАГ, СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ШААРДЛАГААР БИЕЛҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

Дорноговь аймгийн төвийн авто замын засварын ажлыг гүйцэтгүүлэхэд нийгмийн хариуцлагын хүрээнд нийт 110м$^3$ хайрга, 40м$^3$ бетон зуурмагийг үнэ төлбөргүй нийлүүлж хамтран ажилласан. Мөн мод тарих ажлын хүрээнд 2025 онд 100 ширхэг хайлаас, 100ш агч мод өгч байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэн ажиллаж байна.

**Хүснэгт 12. Аймаг, сумын засаг даргаар шаардлагаар биелүүлсэн арга хэмжээ**

| № | Хийсэн ажлын нэр | Байршил | Тусламжийн үнийн дүн |
|---|---|---|---|
| 1 | Аймгийн төвийн авто замын засварын ажлыг гүйцэтгүүлэхэд нийгмийн хариуцлагын хүрээнд нийт 110м$^3$ хайрга, 40м$^3$ бетон зуурмагийг үнэ төлбөргүй нийлүүлж хамтран ажилласан | Дорноговь аймгийн Өргөн сум | - |
| 2 | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд суманд 100ш хайлаас, 100ш агч мод өгч ажилласан | Дорноговь аймгийн Өргөн сум | 600 000 |
| 3 | Онцгой байдлын ерөнхий газарт 26 м3 бетон зуурмаг | | 8600 000 |
| 4 | Тэнгэрийн худаг фестивальд | Өргөн сумын Засаг даргын тамгын газарт | 4000 000 |
| | Нийт | | 13 200 000 |

Зураг 12. Аймаг, сумын засаг даргын шаардлагаар биелүүлсэн арга хэмжээ

ДОРНОГОВЬ АЙМАГ
**ӨРГӨН СУМЫН ЗАСАГ ДАРГА**

200 тоот байшин, Найрамдал гудамж-2, 4 дүгээр баг,
Өргөн сум, Дорноговь аймаг, 44035
Утас/факс: (02-522) 4-43-50
Цахим хаяг: www.urgun.do.gov.mn

2025.10.22 № 01/143

танай__________-ны №__________-т

АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН ДАРГА Н.ОТГОНБАЯР ТАНАА

"Бишрэлт түшлэг" ХХК нь Дорноговь аймгийн Өргөн сумын нутагт орших түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын MV-44000040 тоот тусгай зөвшөөрлийг эзэмшдэг.

Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшиж байх хугацаанд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд суманд 100ш хайлаас, 100ш агч мод өгч ажилласан.

Т.БАТ-АМГАЛАН

D:\bayrsvren\2025 on\toot a5 2025.docx

# БҮЛЭГ 11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөнд Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар 1 жилд 1 удаа сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулсан.  8-р саруудад хийсэн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн хэмжилт дээжлэлтийн үр дүнг Өргөн сумын иргэд танилцуулах санал зөвлөгөө сонгох зорилгоор 9-р сард уулзалт зохион байгуулсан.

**Хүснэгт 13. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт**

| Уурхайн аюулгүй ажиллагаа, хөдөлмөр хамгааллын чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Байгаль орчныг хамгаалахад хэрэгжүүлсэн арга хэмжээ** | Хамарсан цар хүрээ | Хэмжих нэгж | Хэмжээ | Нэгжийн үнэлгээ /мян.төг/ | Нийт зардал /мян.төг/ | Тайлбар | Хэрэгжүүлсэн хувь |
| **Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөнө** | Уурхайн үйл ажиллагаа | Ш | | | 500 000 |  | 100% |
| **Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллаганы хувцас хэрэгсэл болон болзошгүй галын ажилгүй ажиллагааны багаж хэрэгслээр хангана.** | | | Ажилчдын хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангаж ажиллаж байна. | | |  | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Сумаас зохион байгуулж буй урлаг, спортын арга хэмжээг дэмжиж ажиллах** | | | | | | Өргөн сумаас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг бүрэн дэмжиж ажилладаг.<br><br>ДОРНОГОВЬ АЙМАГ<br>ӨРГӨН СУМЫН ЗАСАГ ДАРГА<br>БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН ДАРГА Н.ОТГОНБАЯР ТАНАА<br>Хариу хүргүүлэх тухай<br>Г.БАЯРСАЙХАН | 100% |
| **Ажилчдыг эмнэлгийн анхан шатны үзлэгт хамруулах** | | Ш | 7 | 120 000 | 840 000 | Ажилчдыг аймгийн нэгдсэн эрүүл мэндийн байгууллагатай ажилчдын эмнэлгийн шинжилгээг хийлгэсэн гэрээг хавсаргав. | 100% |
| **Өргөн сумтай хог хаягдлын гэрээ байгуулах** | Хогийн цэг | - | - | | - | Гэрээ байгуулсан. | 100% |
| **Аюултай хог хаягдлыг гэрээ байгуулах** | Засварын газар | | | | - | Эко-аккури ХХК-иар хийлгүүлсэн. | 100% |
| Нийт | | **1340 000** | | | | | **100 хувь** |

## БҮЛЭГ 12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Нийт хийгдсэн ажлуудыг нэгтгэн дүгнэж өмнө 9-р сарын уулзалтаар өгсөн саналыг хэрэгжүүлж эхэлсэн талаар Өргөн сумын иргэд, Дорноговь аймгийн Байгаль орчны газар, Мэргэжлийн хяналтын газруудад танилцуулга хийсэн. Мөн тухайн жилийн биелэлтийн тайланг 2025 оны 11-р сарын 1-ны өдөр аймгийн байгаль орчны газар болон Өргөн сумын  ЗДТГ-т хүргэн өгсөн.

**Хүснэгт 14. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөх оршин суугчид олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөөний биелэлт**

| Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөөний биелэлт | | | |
|---|---|---|---|
| **Уурхайн үйл ажиллагаа, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу хийгдэж буй ажил, нөхөн сэргээлтийн явц зэргийн орон нутгийн иргэдийн төлөөлөлд танилцуулж, бусад сонирхсон асуудлаар чөлөөт ярилцлага хийнэ.** | ЗДТГ-ийн хурлын танхимд төлөвлөгөөг танилцуулна. Тараах материал, зарлалын самбарын зардалд 150000 төг. Танилцуулгад хүрэлцэн ирсэн иргэдэд өдрийн цайнд 100000 төг төсөвлөлөө. 150000+100000=250 000төг | Орон нутгийн иргэд болон байгаль орчны байцаагч нарт уурхайн үйл ажиллагаа тайлагнасан | 100 |
| **Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОУАӨЯ, аймгийн байгаль орчны газар болон Өргөн сумын  ЗДТГ-т хүргэн өгч байна.** | Уурхайн дотоод төлөвлөлтөөр | - | 100 |
| **Нийт** | 250 000 | | 100 |

## ДҮГНЭЛТ

“Бишрэлт түшлэг” ХХК нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугээр сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар шинэчлэн баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу Жаргалантын хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах төслийн 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг боловсрууллаа.

**Хүснэгт 15. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн зардлын нэгтгэл**

| № | Зардлын утга | Нийт зардал, төг |
|---|---|---|
| 1 | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал | 2444 000 |
| 2 | Нөхөн сэргээлтийн ажлын зардал | 2510 000 |
| 3 | Дуйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө | 2500 000 |
| 4 | Тэрбум мод хөтөлбөрийн зардал | 750,000 |
| 5 | Түүх соёлын дурсгалт эд зүйлийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төсөв | - |
| 6 | Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө | 1700 000 |
| 7 | Хог хаягдлын менежментээр хийгдэх ажлын зардал | 1450 000 |
| 8 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал | 676 000 |
| 9 | Аймаг, сумын засаг даргын шаардлагаар биелүүлсэн арга хэмжээ | 13 200 000 |
| 10 | Удирдлага зохион байгуулалтын ажлын зардал | 1340 000 |
| **11** | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь, зардлын задаргаа | 250 000 |
| **Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардлын дүн** | | **26 820 000** |

Бишрэлт түшлэг ХХК нь 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд нийт 26 820 000 төгрөг зарцуулсан байна.

# ХАВСРАЛТ:

НХМаягт МХ 1

Санхүү, эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын 2002 оны 6-р сарын 18-ний 171/111 тоот тушаалын хавсралт

## Бэлэн мөнгөний орлогын баримт

Дугаар [ ] 2025 он 10 сар 21 өдөр

Байгууллагын нэр Байгаль орчны газар

хүлээн авсан

Мөнгө тушаагч Бишрэлт түшлэг ХХК ажилтай

Энхтайван овогтой Уранбилэг - нээс

Гүйлгээний утга Модны суулгац

Тушаасан мөнгөний дүн 600,000 төгрөг 00 мөнгө

Зургаан зуун мянган төгрөг

/үсгээр/

Хавсаргасан баримт ...

Тэмдэг

Дарга ... /

Нягтлан бодогч ... Б. Энхзул /

Хүлээн авсан ... /

Мөнгө тушаагч ... /

ДОРНОГОВЬ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗАР
САНХҮҮ
ДОРНОГОВЬ АЙМАГ
ТТҮ0092 9028668

ъ\



НХМаягт Т-1

Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 347 тоот тушаалын хавсралт

НЭХЭМЖЛЭХ № .....

Нэхэмжлэгч:
Байгууллагын нэр: Хасу Учиг ХХК
РД: 6621317
Хаяг: БГД 4р хороо
Утас, Факс: 99025971
Э_шуудан: hasuuchiga1018
Банкны нэр: Хаан банк
Банкны дансны дугаар: 100000300 5059656208

Харилцагч:
Байгууллагын нэр: Бишрэлт Түшлэг ХХК
РД: 3311007
Хаяг:
Гэрээний №
Нэхэмжилсэн огноо: 2025.10.01
Төлбөр хийх хугацаа: 2025.10.01

| № | Гүйлгээний утга | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ | Нийт үнэ |
|---|---|---|---|---|
| 1 | Өвөл [illegible] | 10 | 255,000 | 2550,000 |
| 2 | Куртик | 10 | 155,000 | 1550000 |
| 3 | Цамц | 10 | 60,000 | 600,000 |
| | | | Дүн | 4700,000 |
| | | | НӨАТ | 470,000 |
| | | | | |
| | | | Нийт дүн | 5170000 |

Мөнгөний дүн: Таван сая нэг зуун далан мянган төгрөг (үсгээр) болно.

Захирал: П.Хулан
Нягтлан бодогч:
(Тамга)

**МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА**

**ТАТВАР ТӨЛСӨН БАРИМТ № - 2251004864457**

| | |
|---|---|
| ТТД / Регистр: | **71000829780 / 9027394** |
| Татвар төлөгчийн нэр: | **Дорноговь аймгийн Өргөн сумын засаг даргын тамгын газар** |
| Татварын төрөл: | **01030723 - Хог хаягдлын үйлчилгээний хураамж** |
| Харъяалах татварын алба: | **Дорноговь / Өргөн** |
| Төлсөн дүн: | **600,000.00** |
| Гүйлгээний огноо: | **2025-10-22 13:47:30** |
| Гүйлгээний утга: | **[2251004864457; 72101445782; 3311007; null; Дорноговь аймгийн Өргөн сумын засаг даргын тамгын газар; 96068132; 5381395655; ДАЛАЙ ШАНД КОНСТРАКШН];5000 99999;96068132** |
| Татварын данс: | **100060700947 / До.Өр Хог хаягдлын хураамж** |
| Төлөлтийн хэлбэр: | |

БАТЛАВ.

ГҮЙЦЭТГЭГЧ:
ДОРНОГОВЬ АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
У. ЭНХМАА

ЗАХИАЛАГЧ:
"БИШРЭЛТ ТҮШЛЭГ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ
Э.УРАНЧИМЭГ

ДОРНОГОВЬ АЙМАГ БИШРЭЛТ ТҮШЛЭГ ХХК 0620060001 3311007 Я СБТ11616

9020045. 5TO542. 6624060072

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2025 оны 10... сарын 15..-ны өдөр №86

Сайншанд

Энэхүү Хамтран ажиллах гэрээ /цаашид гэрээ гэнэ/-г Нэг талаас Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлгийг төлөөлж: Нэгдсэн Эмнэлгийн Эмнэлзүй эрхэлсэн орлогч дарга **М.Чинзориг** /цаашид Нэгдсэн эмнэлэг гэх/, нөгөө талаас **3311007** регистрийн дугаартай "Бишрэлт түшиг" ХХК-ийг төлөөлж захирал **Энхтайван** овогтой **Уранчимэг** /цаашид Компани гэх/ нар Монгол Улсын Иргэний хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл ахуйн тухай хуулийн 14-р зүйл, Эрүүл мэнд, Сангийн Сайдын хамтарсан 2022 оны 49/А/118 дугаар тушаал, Нэгдсэн эмнэлгийн даргын 2022 оны А/37 тоот тушаалыг үндэслэн харилцан тохиролцож хамтран ажиллахаар дараах нөхцөлтэйгээр байгуулав.

**Нэг. Ерөнхий зүйл**

**1.1** Энэхүү гэрээний зорилго нь Нэгдсэн эмнэлгээс үзүүлэх нэмэлт тусламж үйлчилгээг төлбөртэйгээр мэргэжлийн өндөр түвшинд, цаг хугацаанд нь сэтгэл ханамжтай үзүүлэхэд оршино.

1.2 Гэрээний хугацаа: 2025 оны 10 сарын 15-ны өдрөөс 11 сарын 01 хүртэлх хугацаанд үзлэг шинжилгээг гүйцэтгэнэ.

1.3 Гэрээний хавсралт:

1.3.1 Гэрээний хавсралтаар урьдчилсан болон багцын үзлэг хийх үзлэг оношилгооны жагсаалтыг батлав.

1.3.2 Хэвийн бус ажлын байрны хүнд, хортой халуун хөдөлмөрийн нөхцлөөс шалтгаалан эмнэлгийн зүгээс тухайн ажлын байрны нөхцөлд тохирсон урьдчилсан болон багцын үзлэгийг Эрүүл мэндийн сайдын тушаал, журам зааврын дагуу хийж гүйцэтгэнэ.

**Хоёр. Гүйцэтгэгчийн эрх үүрэг**

**2**.1 Нэгдсэн эмнэлэг нь тогтоосон хугацаанд үзлэг оношилгоог чанартай, шуурхай үзүүлнэ.

2.2 Эрүүл мэндийн үзлэгийн хуудсаар хангана.

2.3 Ажилтанд эмчийн үзлэг, оношзүйн шинжилгээ хийж ажилтны эрүүл мэнд мэргэжлийн тохирооны дүгнэлт гаргана.

**Гурав. Захиалагчийн эрх үүрэг**

3.1 Ямар чиглэлээр үзлэг, оношилгоо хийлгэх талаар санал гаргаж, гүйцэтгэгчтэй тохиролцоно.

3.2 Үзлэг оношилгоог чанартай, шуурхай гүйцэтгүүлэх талаар зохих шаардлага тавина.

3.3 Үзлэг оношилгоонд хамрагдах ажилтнуудаа гэрээнд заасан хугацаанд бүрэн хамруулна.

3.4 Ажилтны үзлэгийн хуудсыг хувийн хэрэгт хавсарган хадгалж, байгууллагад мэдээллийн нэгдсэн сан байгуулан хяналт тавина.

3.5 Ажилтны эрүүл мэндтэй холбоотой мэдээллийн нууцыг хуулийн хүрээнд хадгална.

3.6 Эмчийн зөвлөмжийн дагуу ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах, эрүүлжүүлэх, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, эрүүл мэндийн мэдлэг олгох төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангана.

3.7 Үзлэгээр илэрсэн эрүүлжүүлэх шаардлагатай ажилтнуудаа өрх, сум, нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нартай хамтран эрүүлжүүлэх арга хэмжээ авна.

**Дөрөв. Төлбөрийн нөхцөл, төлбөр тооцоо**

4.1 Эмнэлгийн үзлэг, оношилгоонд хамрагдах төлбөр нэг хүний 120,000 төгрөг, нийт 7 хүний **840,000** төгрөг байна.

4.2 Үзлэг шинжилгээнд хамрагдсан ажилтнуудын үзлэгийн төлбөрийг нэхэмжлэхээр Нэгдсэн эмнэлгийн төрийн сан банк **100060020002** До. Нэгдсэн эмнэлэг гэсэн дансанд бүрэн шилжүүлнэ.

**Тав. Давагдашгүй хүчин зүйл**

5.1 Гэрээний аль нэг тал нь давагдашгүй хүчин зүйл болох /газар хөдлөлт, үер, гал түймэр, далайн шуурга, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт/ нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас /алданги, торгууль/чөлөөлөгдөх үндэслэл болно.

5.2 Дээрхи давтагдашгүй хүчин зүйл бий болсон тухай нотолгоог нөгөө талд ирүүлсэн тохиолдолд дээрх заалт хүчин төгөлдөр хэрэгжинэ.

**Зургаа. Гэрээний хариуцлага, маргааныг шийдвэрлэх**

6.1 Аль нэг тал гэрээг зөрчсөнөөс нөгөө талдаа хохирол учруулсан тохиолдолд гэрээг зөрчсөн тал хохирлыг хариуцан барагдуулна.

6.2 Тус гэрээтэй холбоотой маргаан үүссэн тохиолдод харилцан тохиролцож эвээр шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

6.3 Хэрэв талууд тохиролцоонд хүрч чадахгүй тохиолдолд аливаа маргаантай асуудлыг Монгол Улсын Иргэний хууль, бусад хууль тогтоомжийг удирдлага болгон Монгол улсын Шүүхийн байгууллагаар эцэслэн шийдвэрлүүлнэ.

**ГЭРЭЭНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ**

.......................................................................................................................................................
.......................................................................................................................................................
.....................................................................................................................................

2025 оны ..... сарын ...... ны өдөр

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН**

| **Гүйцэтгэгчийг төлөөлж:** | **Захиалагчийг төлөөлж:** |
| --- | --- |
| Эмнэлзүй эрхэлсэн орлогч дарга | "Бишрэлт түшиг" ХХК-ийн захирал |
| М. Чинзориг | Э.Уранчимэг |
| Хаяг: Дорноговь аймаг, Сайншанд сум, Нэгдсэн эмнэлэг | Хаяг: Дорноговь аймаг, Сайншанд сум, 2-р баг |
| Утас: 96686446 | Утас:96068132 |

2025 оны ...10...р сарын ...15...ны
өдрийн ...86....дугаартай гэрээний хавсралт

## Урьдчилан сэргийлэх үзлэгийн багц, төлбөр

| № | Эмчийн үзлэг | Үнэ | Орох хүний тоо | Нийт дүн |
|---|---|---|---|---|
| 1 | Дотор | 15000 | 7 | 105000 |
| 2 | Хэвлийн ЭХО | 15000 | 7 | 105000 |
| 3 | CA 19-9 | 30000 | 7 | 210000 |
| 4 | Цусны дэлгэрэнгүй | 14000 | 7 | 98000 |
| 5 | ОАМ | 6000 | 7 | 42000 |
| 6 | AFP | 25000 | 7 | 175000 |
| 8 | Ерөнхий эмчийн дүгнэлт | 15000 | 7 | 105000 |
| | | | | |
| 9 | ДҮН | | | 840000 |

**ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 1 ДҮГЭЭР ХАВСРАЛТ**

**Тусгай зөвшөөрлийн дугаар 2017/002А**

**Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.**

| Хөдөлгөөний Код Үйлчилгээний төрөл | Өөрчлөлт хөдөлгөөний тайлбар | Гарын үсэг, огноо, тамга |
|---|---|---|
| ТЗ олгосон | • Аймгийн Засаг даргын 2017.05.22-ны А/394 дугаар захирамжаар олгов. Анх олгосон хугацааг 2017.05.23-ны өдрөөр тооцно. | 2017-05-23 |
| Төлбөр | • Тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөр төлсөн | 2017-05-23 |
| Төлбөр төлсөн | • Тусгай зөвшөөрлийн хоёр дахь жилийн төлбөр төлсөн. Хугацаа 2018 оны 5-р сарын 23-ны өдрөөс 2019 оны 05-р сарын 23-ны өдөр хүртэл хүчинтэй. | 2018-05-28 |
| Төлбөр | • Тусгай зөвшөөрлийн гурав дахь жилийн төлбөр төлсөн | 2019.05.20 |
| Төлбөр | • Тусгай зөвшөөрлийн дөрөв дэх жилийн төлбөр төлсөн | 2020.05.05 |
| Төлбөр | • Тусгай зөвшөөрлийн тав дахь жилийн төлбөр төлсөн | 2021.08.05<br>ЕЮА0004 |
| Төлбөр | • Тусгай зөвшөөрлийн зургаа дахь жилийн төлбөр төлсөн<br>• Тусгай зөвшөөрлийн 7 дахь жилийн төлбөр төлсөн | 2023.01.23<br>2023.10.17<br>ЕЮА0004 |
| Төлбөр | • Тусгай зөвшөөрлийн 8 дахь жилийн төлбөр төлсөн | 2024.10.08<br>ЕЮА0004 |

ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, 3 дугаар баг,
Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103
Утас/Факс: (976) 7052 3036,
Цахим шуудан: zdtg@dornogovi.gov.mn,
Цахим хуудас: www.dornogovi.gov.mn

2025.10.21 № 03/1621
танай ____________-ны №____________-т

ТОДОРХОЙЛОЛТ

"Бишрэлт түшлэг" ХХК нь аймгийн төвийн авто замын засварын ажлыг гүйцэтгүүлэхэд нийгмийн хариуцлагын хүрээнд нийт 110$м^3$ хайрга, 40$м^3$ бетон зуурмагийг үнэ төлбөргүй нийлүүлж хамтран ажилласан болно.

ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.БАТ-ЭРДЭНЭ

4425150721
d/ajil/bichig/toot

ДОРНОГОВЬ АЙМАГ
**ӨРГӨН СУМЫН ЗАСАГ ДАРГА**

200 тоот байшин, Найрамдал гудамж-2, 4 дүгээр баг,
Өргөн сум, Дорноговь аймаг, 44035
Утас/факс: (02-522) 4-43-50
Цахим хаяг: www.urgun.do.gov.mn

2025.10.22 № 01/143

танай ______________ -ны № ______________ -т

АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН
ДАРГА Н.ОТГОНБАЯР ТАНАА

"Бишрэлт түшлэг" ХХК нь Дорноговь аймгийн Өргөн сумын нутагт орших түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын MV-44000040 тоот тусгай зөвшөөрлийг эзэмшдэг.

Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшиж байх хугацаанд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд суманд 100ш хайлаас, 100ш агч мод өгч ажилласан.

Т.БАТ-АМГАЛАН

D:\bayrsvren\2025 on\toot a5 2025.docx

ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР
**САЙНШАНД СУМ ДАХЬ ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ, АВРАХ 33 ДУГААР АНГИ**

44107 Дорноговь аймаг, Сайншанд сум, 1 дүгээр баг,
Утас: (705) 2-30-66
И-мэйл: www.dornogobi101.com

2025.10.30 № 02

танай____________-ны №____________-т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН ДАРГА Н.ОТГОНБАЯР ТАНАА

"Бишрэлт түшлэг" ХХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах, аврах 33 дугаар ангитай хамтран ажилладаг нь үнэн болно.

ЗАХИРАГЧ
АХМАД А.БИЛГҮҮН

ДОРНОГОВЬ АЙМАГ
**САЙНШАНД ХОТЫН
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБА
ТОДОРХОЙЛОЛТ**

Сайншанд сумын ЗДТГ-ын байр, Залуучуудын гудамж, 3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103, Утас: (976) 7052 2229
Цахим шуудан: zaa@sainshand.do.gov.mn
Цахим хуудас: www.zaa@sainshand.do.gov.mn

2025.10.30 № 02

ДОРНОГОВЬ АЙМГИЙН БАЙГАЛЬ
ОРЧНЫ ГАЗРЫН ДАРГА
Н.ОТГОНБАЯР ТАНАА

"Бишрэлт түшлэг" ХХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд Дорноговь аймгийн Сайншанд сумын нийтийн эзэмшлийн зам засвар, тохижилтын ажилд хайрга нийлүүлж хамтран ажилладаг нь үнэн болно.

ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.ЭНХЧИМЭГ

3310302. 0621070007. ЭТО044

4425110113

ДОРНОГОВЬ АЙМАГ
БАТЛАВ
"БИШРЭЛТ ТҮШЛЭГ" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Э.УРАНЧИМЭГ
БИШРЭЛТТҮШЛЭГ ХХК
0620060001
3311007 ☎ СБТ11616

# "БИШРЭЛТ ТҮШЛЭГ" ХХК-ИЙН БАРИЛГЫН БОЛО Н ЗАМЫН ДАЙРГА БУТЛАН АНГИЛАХ ҮЙЛДВЭРИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

**ХЯНАСАН**:
ДОРНОГОВЬ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨЛТ БЭЛЭН БАЙДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН, ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧ, ХОШУУЧ ..............................Г.ГАНБАЯР/

**БОЛОВСРУУЛСАН:**
"БИШРЭЛТ ТҮШЛЭГ" ХХК-ИЙН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ ЭРҮҮЛ АХУЙН АЖИЛТАН.................Я.ЦОЛМОНБААТАР/

ДОРНОГОВЬ АЙМАГ
БИШРЭЛТТҮШЛЭГ ХХК
0620060001
3311007 ☎ СБТ11616

Сайншанд хот
2025 он

ДОРНОГОВЬ АЙМГИЙН УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

**ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН**

| | |
|---|---|
| Дугаар, он /№ | : 2025/120 |
| Сорьцыг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас | : "Бишрэлт Түшлэг" ХХК |
| Сорьцыг авсан хүний нэр, албан тушаал | : Б. Хандсүрэн /Лабораторийн инженер/ |
| Сорьцын төрөл, тоо | : Хөрс агрохими-3 |
| Хүлээн авсан огноо | : 2025.09.22 |
| Сорьцын тодорхойлолт | : Дорноговь аймаг, Өргөн сум |
| Шинжилсэн огноо | : 2025.10.01-10 |
| Хуудасны тоо | : 1 |

**Үр дүн**

| № | Цэгийн нэр | pH | Чийг % | Нитратын азот /$NO_3$/ мг/кг | Сульфат /$SO_4$/ мг/кг | Фосфор /$P_2O_5$/ мг/кг | Амиакийн азот /$NH_4$/ мг/кг | Ялзмаг % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бутлуурын хэсэг N 44°48'06.7" E 110°19'48.1" | 8.97 | 4.14 | 20.90 | 304.5 | 68.26 | 9.12 | 0.19 |
| 2 | Карерь N 44°48'01.1" E 110°19'39.8" | 9.00 | 3.77 | 3.95 | 46.0 | 21.78 | 8.29 | 0.59 |
| 3 | Харьцуулсан хөрс N 44°48'07.3" E 110°19'71.0" | 8.85 | 1.97 | 1.84 | 29.2 | 58.64 | 8.94 | 2.04 |

Шинжилгээ гүйцэтгэсэн: Лабораторийн технологич инженер О. Бат-Оюун О.Бат-Оюун
Хянаж баталгаажуулсан: УЦУОШТөвийн дарга Ш.Амарбилэг

9025995 ☎ 4418262647

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

## ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

| | |
|---|---|
| Дугаар он /№ | : 2025/122 |
| Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас | : "БИШРЭЛТ ТҮШЛЭГ" ХХК |
| Дээжийг авсан хүний нэр, албан тушаал | : Б. Хандсүрэн /Лабораторийн инженер/ |
| Дээжийн тоо, төрөл | : 2, Ус |
| Хүлээн авсан огноо | : 2025.10.01 |
| Дээжийн тодорхойлолт | : Дорноговь аймаг, Сайншанд сум |
| Шинжилсэн огноо | : 2025.10.01-06 |
| Хуудасны тоо | : 2 |

**Үр дүн:**

| № | | **Бишрэлт Түшлэг гүний худгийн ус** N 44°53'81.3" E 104°08'38.1" | **Чандмань илч худгийн ус** N 44°53'81.3" E 104°08'38.1" | **MNS 0900:2018** |
|---|---|---|---|---|
| **1** | Усан орчин /pH/ | 7.95 | 7.86 | **6.5-8.5** |
| **2** | Цахилгаан дамжуулах чанар /EC/ μS/см/ | 1187 | 1282 | **-** |
| **3** | Кальцийн ион /Ca/ мг/л | 31.3 | 34.1 | **100** |
| **4** | Магнийн ион /Mg/ мг/л | 3.4 | 14.8 | **30** |
| **5** | Сульфатын ион /$SO_4$/ мг/л | 361 | 506 | **500** |
| **6** | Хлорын ион /CL/ мг/л | 134 | 115 | **350** |
| **7** | Гидрокарбонатын ион /$HCO_3$/ мг/л | 226 | 229 | **-** |
| **8** | Эрдэсжилт мг/л | 1084 | 1264 | **-** |
| **9** | Хатуулаг экв/л | 1.8 | 2.9 | **7.0** |
| **10** | Жинлэгдсэн бодис | 18 | 14 | **-** |
| **11** | Перманганатын исэлдэх чанар мг/л | 0.5 | 0.3 | **-** |
| **12** | Аммонийн азот /$NH_4$/ мг/л | 0.02 | 0.17 | **1.5** |
| **13** | Нитритийн азот /$NO_2$/ мг/л | 0.001 | 0.002 | **1** |
| **14** | Нитратийн азот /$NO_3$/ мг/л | 0.11 | 2.32 | **50** |
| **15** | Эрдэс фосфор /$PO_4^{3}$/ мг/л | 0.111 | 0.114 | **3.5** |
| **16** | Фтор /F/ мг/л | 1.29 | 0.83 | **0.7-1.5** |
| **17** | Төмөр /Fe/ мг/л | 1.01 | 0.06 | **0.3** |

Шинжилгээ гүйцэтгэсэн: Лабораторийн инженер Ч. Түмэннаст
Хянасан: Лабораторийн технологич инженер О. Бат-Оюун
Баталгаажуулсан: УЦУОШТөвийн дарга Ш. Амарбилэг

ДОРНОГОВЬ АЙМГИЙН УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

## ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

| | |
|---|---|
| Дугаар, он /№ | : 2025/121 |
| Сорьцыг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас | : "Бишрэлт Түшлэг" ХХК |
| Сорьцыг авсан хүний нэр, албан тушаал | : Б. Хандсүрэн /Лабораторийн инженер/ |
| Сорьцын төрөл, тоо | : $SO_2$-2, $NO_2$-2, Нийт тоос-2 |
| Хүлээн авсан огноо | : 2025.10.01 |
| Сорьцын тодорхойлолт | : Дорноговь аймаг, Өргөн сум |
| Шинжилсэн огноо | : 2025.10.01-03 |
| Хуудасны тоо | : 1 |

**Үр дүн**

| № | Дээж авсан цэгийн нэр | Хүхэрлэг хий, $SO_2$ мг/м$^3$ | Азотын давхар исэл, $NO_2$ мг/м$^3$ | Нийт тоосны агууламж мг/м$^3$ |
|---|---|---|---|---|
| 1 | Бутлуурын хэсэг<br>N 44°48'06.7"<br>E 110°19'48.1" | 0.017 | 0.036 | 2.58 |
| 2 | Карерь<br>N 44°48'01.1"<br>E 110°19'39.8" | 0.007 | 0.011 | 0.029 |
| **ЗДХ** | **MNS4585:2025** | **0.450** | **0.200** | **0.500** |

Шинжилгээ гүйцэтгэсэн: Лабораторийн инженер Ч. Түмэннаст
Хянасан: Лабораторийн технологич инженер О. Бат-Оюун
Баталгаажуулсан: УЦУОШТөвийн дарга Ш.Амарбилэг

9025995 ⁂ 4418262647

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

БАТЛАВ. ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ӨРГӨН СУМЫН ЗАСАГ ДАРГА
Г.БАЯРБОЛД

**ХОГ ХАЯГДЛЫН ГЭРЭЭ**

**№12**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1 Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Хог хаягдлын тухай хуулийн 8.4, 9.2, 20.1,20.2, Сумын ИТХ-ын 2023 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн 10/07 дугаар тогтоолыг үндэслэв.

1.2 Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх хортой нөлөөллийг арилгах түүнээс урьдчилан сэргийлэх ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, дахин боловсруулж эргүүлэн ашиглах, тээвэрлэх, булах болон орчны ариун цэврийг тогтмол цэвэр байлгах, цэвэр эрүүл орчинд ажиллаж амьдрах орчныг бий болгоход оршино.

**Хоёр. Гэрээ байгуулагч талууд**

2.1 Нэг талаас **Дорноговь** аймгийн **Өргөн** сумын ЗДТГ-ыг төлөөлж Байгаль орчны бодлогын мэргэжилтнийг түр орлон гүйцэтгэгч **Э.Баярсүрэн** нөгөө талаас **3311007** дугаар регистрийн "**Бишрэлт түшлэг" ХХК-** ийн **захирал Э.Уранчимэг** нар харилцан тохиролцож **2024** оны **01** дүгээр сарын **02**-ны өдрөөс **2024** оны **12** дугаар сарын **31**-нийг хүртэл хугацаатайгаар энэхүү гэрээг байгуулав.

**Гурав. Сумын ЗДТГ-ын эрх үүрэг**

3.1 Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль Хог хаягдлын хуулийн дагуу хяналт тавьж ажиллана.

3.2 Аж ахуй нэгж байгууллагын барилгын хог хаягдал гаргасан хураамжийг Сумын ИТХ-ын 2023 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн 10/07 тоот тогтоолоор Ахуйн хэрэглээний хог хаягдал уурхайн 1 сарын 50,000 төгрөгөөр тооцно.

**Дөрөв. "БИшрэлт түшлэг" ХХК-ийн хүлээх эрх үүрэг**

4.1.Өөрийн байгууллагын үйл ажиллагаанаас гарсан ахуйн хог хаягдал, Үйлдвэрлэлийн хог хаягдлыг стандартын шаардлага хангасан зориулалтын саванд ангилан хадгалж байх.

4.2.Аж ахуйн нэгж байгууллага нь хог хаягдал гаргасны хураамжийг сумын төрийн сан банкны **100060700947** тоот дансанд бүрэн төлөх

4.3.Тус сумын нутагт төлөх нийт төлбөр:
12 сар*50,000 /1 сарын төлбөр/=600,000 /зургаан зуун мянган төгрөг/.

**Нийт төлбөр:** 600,000 /зургаан зуун мянган төгрөг /

4.5.Ахуйн хогийг тогтсон хугацаанд цэвэрлэж тээвэрлэх, хог хаягдлын талаарх дүрэм журам, стандартын шаардлагыг хангаж зориулалтын цэгт хаяж байхад анхаарах.

4.6.Үйлдвэр үйлчилгээний явцад үүсдэг хог хаягдлын хэмжээ, бусад мэдээллийг Сумын ЗДТГ-т мэдээлж байх.

4.7.Хог хаягдлыг ангилан хаях талаар зохих мэдээллийг ажилтнуудад эзэмшүүлж, сургалт сурталчилгаа явуулах аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж ажиллах.

4.8.Аюултай хог хаягдлыг зориулалтын бус газар хаяхыг хатуу хориглоно.

4.9.Барилгын хог хаягдлыг зориулалтын бус газар хаяхыг хатуу хориглоно.

**Тав. Гэрээний хариуцлага**

5.1 Аж ахуйн нэгж байгууллага нь хог хаягдал гаргасны төлбөрөө төлөөгүй болон ил задгай шатаасан, зориулалтын бус газар хог хаяг хаясан нөхцөлд өр авлагыг барагдуулах ба учруулсан хохиролыг арилгуулах шаардлагатай тохиолдолд холбогдох дээд шатны байгууллагад хандан хог хаягдлын тухай хуулийн дагуу хариуцлага тооцно.

5.2 Аж ахуй нэгж байгууллага нь энэхүү гэрээнд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл хоёр талын хамтарсан төлөөлөгч тухай бүр шийдвэрлэнэ.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

| | |
|---|---|
| ӨРГӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН | "БИШРЭЛТ ТҮШЛЭГ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ |
| /Э.БАЯРСҮРЭН/ | /Э.УРАНЧИМЭГ/ |
| УТАС: 88049952 | УТАС: 96068132 |

# ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИГ

2025 оны 10 дугаар сарын 30-ны өдөр

Сайншанд хот

## НЭГ: НИЙТЛЭЛ ҮНДЭСЛЭЛ

Энэхүү хамтран ажиллах санамж бичиг /цаашид Санамж бичиг гэх/-ийг нэг талаас ЭКО ГОВЬ ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР, нөгөө талаас Сайншанд суманд байрлах **БИШРЭЛТТҮШЛЭГ ХХК** нь байгаль орчноо хамгаалах нийгмийн хариуцлагын хүрээнд байгууллагынхаа хэмжээнд цугларсан хуванцар савны төрлийн дахивруудыг үйлдвэрт тогтмол нийлүүлэх, хамтран ажиллах зорилгоор байгуулав.

## ХОЁР: ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ

Талууд дараах хүрээнд хамтран ажиллана. Үүнд:

- Тус байгууллага нь байгууллагынхаа ажилчдын хүрээнд дахивраа цуглуулахад уриалах, идэвхижүүлэх,
- Тус байгууллага нь тохирсон хуваарийн дагуу сард эсвэл долоо хоногт нэг удаа цугларсан дахивруудыг үйлдвэрт авчирч тушаах,
- Үйлдвэр нь тушаасан дахиврыг хөрсөнд булшлагдахаас сэргийлж дахин боловсруулалтанд оруулах, мөн дахивар ангиллын сургалт, мэдээллээр хангах тус тусын эрх үүргийг хүлээнэ.

## ГУРАВ: ХУГАЦАА

Энэхүү санамж бичгийг 1 /нэг/ жилийн хугацаатай байгуулав.

## ДӨРӨВ: БУСАД

- Талууд санамж бичигт дурдсан ажлуудыг өөрсдийн байгууллагын байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны үндсэн чиглэлтэй холбож, хариуцлагатай хэрэгжүүлнэ.
- Талууд цаашдын хамтын ажиллагааны үндэс болох энэхүү санамж бичигт гарын үсэг зурснаар аливаа санхүүтэй холбоотой хариуцлага хүлээгээгүй болно.

## САНАМЖ БИЧГИЙГ БАЙГУУЛСАН:

| | |
|---|---|
| ЭКО ГОВЬ үйлдвэрийн захирал: | БИШРЭЛТТҮШЛЭГ ХХК төлөөлж захирал: |
| Э. ГАН-ЭРДЭНЭ | Э. УРАНЧИМЭГ |

Reduce. Reuse. Recycle.

БАТЛАВ
"ШАНД АРИУТГАЛ" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ ............ Ж.БАТЧУЛУУН

ДОРНОГОВЬ АЙМАГ
ШАНД АРИУТГАЛ ХХК

БАТЛАВ
ЗАХИРАЛ

ДОРНОГОВЬ АЙМАГ
БИШРЭЛТТҮШЛЭГ ХХК
0620060001
3311007 СБТ11516

**АХУЙН ХОРТОН ШАВЖ, МЭРЭГЧ УСТГАХ, ХАЛДВАРГҮЙТГЭЛИЙН**

**АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

2025 оны 08 сарын 1 өдөр №159 Сайншанд хот

Нэг талаас "Бишрэлт түшлэг" ХХК /цаашид захиалагч/ гэх түүнийг төлөөлж Захирал ажилтай Э. Уранцэцэг нь нөгөө талаас Дорноговь аймаг, Сайншанд сум, 2-р багт байрлах 3319288 тоот регистрийн дугаар, ЭХ-18/08/99 тоот тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаартай **"Шанд ариутгал" ХХК** /цаашид гүйцэтгэгч/ гэх, хамтад нь / /Талууд / гэх түүнийг төлөөлж захирал Ж.Батчулуун нарын хооронд Монгол Улсын Иргэний хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл ахуйн тухай хууль, ариутгал халдваргүйтгэл, шавж мэрэгч устгалын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, стандарт, техникийн зохицуулалт, хортон шавжийн хяналтын журам, заавар эрх зүйн хэм хэмжээний хүрээнд дараах нөхцөлүүдийг харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

**НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

1.1. Энэхүү гэрээг Монгол улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1.5-т заасны дагуу, орчны эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах, эрүүлжүүлэх, халдварт өвчин тархахаас сэргийлэх зорилготой болно.

1.2. MNS5161-3:2002 Ахуйн шавж, мэрэгч устгах, халдваргүйжүүлэх үйлчилгээг стандартын дагуу хийж гүйцэтгэснээр гадаад орчин дахь өвчин үүсгэгч бичил биетэн, ахуйн шавж мэрэгчийн тоог устгах буюу цөөрүүлж аливаа халдварт өвчний дамжих замыг таслан зогсооход чиглэгдэнэ.

**ХОЁР. ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ХУГАЦАА, АЖЛЫН ХӨЛС**

2.1.1. Энэхүү гэрээг талууд гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс буюу 2025 оны 08 сарын 1 өдрөөс эхлэн 2026 оны 08 сарын 01 өдөр хүртэл 1 жилийн хугацаагаар байгуулав.

2.1.2. Гэрээг дахин 20.... оны .... сарын .... өдрөөс эхлэн 20...... оны ...... сарын ........ өдөр хүртэл ........... жилийн хугацаагаар сунгав.

2.2. Ариутгал, халдваргүйжүүлэлт, шавж мэрэгч устгалын ажлын хийх өдөр цаг хугацааг харилцан тохиролцоно.

2.3. Ариутгал, халдваргүйжүүлэлт, шавж мэрэгч устгалыг хийхтэй холбогдуулан дараах нөхцлүүдийг харилцан тохиров.

2.3.1. Урьдчилан сэргийлэх халдваргүйтгэл, шавж, мэрэгч устгалд хамрагдах талбайн хэмжээг захиалагч тал нь гэрээнд заасны дагуу тухайн үйлчилгээг хийхийн өмнө үнэн зөв тооцоолон гаргаж өгөх ба хамрагдвал зохих талбайгаа бүрэн хамруулна.

2.3.2. Гүйцэтгэгч байгууллага нь ажлын нэгж үнэлгээ болох 1 м.кв-аар тооцон тухайн халдваргүйтгэл, шавж, мэрэгч устгалын ажлыг чанартай сайн хийж гүйцэтгэж, мөн мэргэжил арга зүйн зөвлөгөө өгнө.

2.3.3. Гүйцэтгэгч тал ажлаа бүрэн гүйцэтгэж дуусаад, захиалагч талд хүлээлгэн өгсний дараа захиалагч тал гүйцэтгэгчийн нэхэмжлэхийг үндэслэн гэрээт ажлын гүйцэтгэлийн үйлчилгээний хөлсийг тогтсон хугацаанд шилжүүлэх бөгөөд гүйцэтгэгч тал НӨАТ-ын баримтыг тухай бүр шивж өгнө.

## ГУРАВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

**3.1. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг:**

3.1.1. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу, тухайн ажлыг гэрээнд заасан хугацаанд багтаан чанартай, бүрэн хийж гүйцэтгэнэ.

3.1.2. Байгууллага, аж ахуй нэгжид халдваргүйтгэл болон шавж, мэрэгч устгалын ажлыг зөвшөөрөгдсөн хор, бодисоор, тохирсон тун хэмжээгээр мэргэжлийн өндөр түвшинд хийж үйлчилнэ.

3.1.3.Хамрагдвал зохих талбайг бүрэн хэмжээгээр хамруулан хийх үүрэгтэй ба захиалагч талаас тавих хяналт, тэдгээрийн хүсэлт шаардлагыг хангаи биелүүлнэ.

3.1.4. Гэрээт ажил гүйцэтгэх газарт ажиллахдаа хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм, зааврыг бүрэн хангаж ажиллана.

3.1.5. Гүйцэтгэгч нь ариутгал халдваргүйтгэл, шавж мэрэгч устгалын ажлыг бүрэн гүйцэд хийж гүйцэтгэсэний дараа хийсэн ажлын тайлан, ашигласан бодис түүний орц найрлагын талаар захиалагч талд танилцуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгөх үүрэгтэй.

**3.2. Захиалагчийн эрх, үүрэг:**

3.2.1. Халдваргүйтгэл, шавж мэрэгч устгалын ажлын хийх график хугацааг хамтран гаргаж, түүнийг хэрэгжүүлэхэд гүйцэтгэгч байгууллагатай хамтран идэвхтэй ажиллана.

3.2.2. Гүйцэтгэгч байгууллагын зөвлөмжийн дагуу өөрийн байгууллага дээр бэлтгэл ажлыг сайтар хангаж ажиллана.

3.2.3. Халдваргүйтгэл, шавьж, мэрэгч устгал хийхийн өмнө их цэвэрлэгээ хийж, байрны хонгил болон талбайг ус чийггүй болгох, хананаас эд юмсыг тодорхой хэмжээнд чөлөөлж, зай завсар гаргасан байвал зохино.

3.2.4. Захиалагч нь гүйцэтгэгч байгууллагын нэхэмжлэхээр үйлчилгээний хөлсийг харилцах дансанд нь тухайн цаг хугацаанд нь бүрэн шилжүүлэх, юмуу бэлэн мөнгөөр төлөх үүрэгтэй.

3.2.5. Халдваргүйтгэл, шавж, мэрэгч устгалд хамруулвал зохих талбайг бүрэн гүйцэт хамруулах үүрэгтэй.

## ДӨРӨВ. АЖЛЫН ҮР ДҮН ХҮЛЭЭЛЦЭХ

4.1. Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг бүрэн хийж гүйцэтгэж, захиалагчид хүлээлгэн өгөх ба талууд хамтран шалган, баримтжуулан, гарын үсэг зурж, акт үйлдэж хүлээлгэн өгнө.

4.2. Хэрэв гүйцэтгэсэн ажил нь гэрээнд заасан шаардлагад нийцээгүй, чанаргүй гүйцэтгэсэн нь тогтоогдсон тохиолдолд гүйцэтгэгч нь тухайн доголдлыг засч, үнэ төлбөргүй өөрийн зардлаар хийж гүйцэтгэж, хүлээлгэн өгнө.

4.3.Захиалагч тал нь үйлчилгээ тус бүрд төлбөрийн нэхэмжлэхийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногт багтаан төлбөрийн **ХААН БАНК 5381211002 ТООТ ДАНСАНД ХИЙНЭ.**

## ТАВ. ХАРИУЦЛАГА

5.1. Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг заасан хугацаанд чанартай хийж гүйцэтгэнэ.

5.2. Гүйцэтгэгч, захиалагч нарын гэрээт ажил нь Монгол улсад мөрдөгдөж буй холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын шаардлагад нийцээгүй, үүний улмаас үүсэх хохирол хариуцлагыг буруутай гэх талууд үл маргах журмаар бүрэн хариуцаж шийдвэрлэнэ.

5.3. Гэрээнд хоёр тал гарын үсэг зурж, тамга тэмдэг ажил гүйцэттэх гэрээ хүчин төгөлдөр болох бөгөөд хуулийн ижил хүчинтэй болно.

5.4. Гэрээний хугацаа дууссан нөхцөлд 2 тал харилцан тохиролцож гэрээг сунгах асуудлыг шийдвэрлэнэ.

## ЗУРГАА. ДАВТАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

6.1. Талуудын гэрээний хяналтаас гадуур , урьдчилж тооцох, давах туулах боломжгүй гэрээ байгуулсны дараа үүссэн, гэрээгээр хүлээсэн үүргээ хэсэгчлэн болон бүрэн биелүүлэх боломжгүй, эсвэл гэнэтийн буюу давтагдашгүй хүчин зүйлийн шинжтэй / байгалийн гамшиг, гал түймэр, үер ус, дэмбэрэлт, үймээн гм бусад/ нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй тохиолдолд нэн даруй нөгөө талд мэдэгдэнэ. Талууд харилцан тохиролцож асуудлыг шийдвэрлэнэ.

## ДОЛОО. БУСАД ЗҮЙЛ

7.1.Энэхүү гэрээг талуудын зөвшөөрөлгүйгээр бусдад дамжуулах, өөрийн эрх үүргийг өөр бусад этгээдэд шилжүүлэхгүй.

7.2.Энэхүү гэрээтэй холбоотой талуудын хоорондын маргааныг талууд харилцан хэлэлцэж, эвийн журмаар шийдвэрлэнэ.

7.3.Гэрээтэй холбоотой маргааныг шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Монгол Улсын хуулийн дагуу Монгол Улсын Шүүхээр шийдвэрлэнэ.

7.4. Гэрээг 2хувь үйлдэж, тал бүр 1хувийг хадгалсан нь хуулийн ижил хүчинтэй байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

ГҮЙЦЭТГЭГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:
"ШАНД АРИУТГАЛ"ХХК-ИЙН ЗАХИРАЛ
Ж.БАТЧУЛУУН УТАС 99078248

ЗАХИАЛАГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ: